



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/217

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Бүсийн сургалт судалгааны “Нийгмийн захиалга” Төрийн бус байгууллага хоорондын гэрээний дагуу хийгдсэн “Хүүхэд хамгааллын нөхцөл байдлын үнэлгээ” судалгааны ажлын үлдэгдэл санхүүжилтэд 2.654.520 төгрөгийн зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 2.654.520 төгрөг /Хоёр сая зургаан зуун тавин дөрвөн мянга таван зуун хорь/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.18 дахь заалтын “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих” төсөл, хөтөлбөрийн зардлаас тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Уранчимэг/-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

